



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Луус сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2024/152/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="http://www.open.audit.mn">www.open.audit.mn</a>	Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох Утас: 70592439 Цахим хаяг: <a href="mailto:Munkhtogtokhr@audit.gov.mn">Munkhtogtokhr@audit.gov.mn</a>
Дундговь аймаг 2024 он	Аудитын менежер: Х.Наранцацрал Утас: 70592225 Цахим хаяг: <a href="mailto:Narantsatsralkh@audit.gov.mn">Narantsatsralkh@audit.gov.mn</a>
	Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК Захирал: Х.Ариунзул Утас: 99077062 Цахим хаяг: <a href="mailto:ikhayadaudit@gmail.com">ikhayadaudit@gmail.com</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум  
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208.  
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2024-02-26 № 89

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Луус сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Луус сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант оны дундуур халаалтын тарифыг нэмэгдүүлж мөрдүүлсэнтэй холбоотой үүссэн өр төлбөр болон Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 07 сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалинг нэмсэн, бараа материалын үнэ, тарифын өсөлттэй холбоотой нийт зардал өмнөх оноос 1.2 дахин өссөн байна. Уг үйл явцыг санхүүгийн тайланд толилуулсан бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

#### Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй байна.

#### Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын бичиг баримт болон хуулиар олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлэх ажлын 1 хөтөлбөрийн 8 арга хэмжээг 99.0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлэн тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Р.МӨНХТОГТОХ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>110,014,568.28</b>	<b>117,180,675.46</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	43,654,000.28	45,286,277.46
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	43,654,000.28	45,286,277.46
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	43,654,000.28	45,286,277.46
31211	Төрийн сангийн харилцах	42,254,000.21	45,278,227.39
312118	Ахмадын сангийн харилцах	1,400,000.07	8,050.07
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	23,494.00	125,000.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	23,494.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	-	125,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	125,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	66,337,074.00	71,769,398.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	14,380,066.00	14,293,966.00
35110	Тусгай зориулалттай материал	13,025,766.00	12,955,666.00
35130	Эм боох материал	1,354,300.00	1,338,300.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	51,957,008.00	57,475,432.00
35410	Бичиг хэргийн материал	5,220,760.00	4,574,847.00
35420	Аж ахуйн материал	32,857,888.00	34,869,419.00
35440	Түлш, шатах тослох материал	192,500.00	-
35450	Барилгын засварын материал	8,644,250.00	7,614,750.00
35460	Хүнсний материал	4,897,610.00	10,272,416.00
35470	Бусад хангамжийн материал	144,000.00	144,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>560,028,714.77</b>	<b>527,734,894.58</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	560,028,714.77	527,734,894.58
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	546,028,714.77	513,734,894.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	513,264,038.46	513,264,038.46
39202	Хуримтлагдсан элэгдэл	(40,420,827.56)	(51,684,603.56)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	71,545,466.00	75,809,266.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(29,935,687.81)	(45,549,114.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	60,720,571.43	60,720,571.43
39208	Хуримтлагдсан элэгдэл	(29,372,759.04)	(38,828,596.17)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,780,000.00	1,780,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,552,086.72)	(1,776,666.72)
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	14,000,000.00	14,000,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	14,000,000.00	14,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>670,043,283.05</b>	<b>644,915,570.04</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b>2,118,638.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	2,118,638.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	2,118,638.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	199,413.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	-	1,919,225.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>670,043,283.05</b>	<b>642,796,932.04</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	670,043,283.05	642,796,932.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	83,079,720.00	83,079,720.00
51101	Өмч: - төрийн	83,079,720.00	83,079,720.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	586,963,563.05	559,717,212.04
51210	Өмнөх үеийн үр дүн	586,963,563.05	586,963,563.05
51220	Тайлант үеийн үр дүн	-	(27,246,351.01)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>670,043,283.05</b>	<b>644,915,570.04</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>972,873,152.14</b>	<b>327,728,500.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>653,183,352.14</b>	<b>4,298,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	653,183,352.14	4,298,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	653,183,352.14	4,298,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,953,500.07	35,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	651,229,852.07	4,263,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>319,689,800.00</b>	<b>323,429,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	262,942,500.00	291,100,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	262,942,500.00	291,100,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	-
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	56,747,300.00	32,329,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,747,300.00	32,329,500.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>303,193,724.09</b>	<b>354,974,851.01</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>303,193,724.09</b>	<b>354,974,851.01</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	300,484,139.71	354,801,870.53
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	176,171,495.00	221,691,584.00
210101	Үндсэн цалин	129,680,584.00	143,246,188.00
210102	Нэмэгдэл	34,729,641.00	73,214,172.00
210104	Урамшуулал	11,761,270.00	5,231,224.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,308,454.79	27,495,295.82
210201	Тэтгэврийн даатгал	14,691,413.49	18,860,655.36
210202	Тэтгэмжийн даатгал	2,433,228.93	2,214,554.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,415,193.98	1,541,674.24
210204	Ажилгүйдлийн даатгал	342,601.40	645,187.84
210205	Эрүүл мэндийн даатгал	3,426,016.99	4,233,223.82
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	23,384,002.62	30,732,794.52
210301	Гэрэл, цахилгаан	1,398,577.62	1,797,569.52
210302	Түлш, халаалт	20,445,425.00	26,405,225.00
210303	Цэвэр, бохир ус	1,540,000.00	2,530,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	6,518,245.00	5,646,199.00
210401	Бичиг хэрэг	4,020,190.00	2,496,360.00
210402	Тээвэр, шатахуун	1,130,375.00	652,730.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	64,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,367,680.00	2,159,909.00
210408	Бараа материал ақталсны зардал	-	272,300.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	18,815,207.50	23,634,077.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	101,000.00	30,540.00
210502	Хоол, хүнс	18,714,207.50	23,603,537.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,700,701.00	4,128,950.00
210604	Урсгал засвар	18,700,701.00	4,128,950.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	579,700.00	259,600.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	579,700.00	259,600.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	34,006,333.80	41,213,370.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,498,700.00	4,655,750.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,507,633.80	36,557,620.19
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,709,584.38	172,980.48
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,992,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,992,300.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	717,284.38	172,980.48
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>669,679,428.05</b>	<b>(27,246,351.01)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>669,679,428.05</b>	<b>(27,246,351.01)</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>321,643,300.07</b>	<b>323,464,700.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>1,953,500.07</b>	<b>35,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	1,953,500.07	35,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,953,500.07	35,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	553,500.00	35,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,400,000.07	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>319,689,800.00</b>	<b>323,429,700.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	262,942,500.00	291,100,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	262,942,500.00	291,100,200.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	56,747,300.00	32,329,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	56,747,300.00	32,329,500.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>277,269,309.79</b>	<b>321,832,422.82</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>277,269,309.79</b>	<b>321,832,422.82</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>274,559,725.41</b>	<b>321,659,442.34</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	175,831,134.00	221,462,222.75
210101	Үндсэн цалин	129,340,223.00	165,453,477.55
210102	Нэмэгдэл	34,729,641.00	47,689,447.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,700,000.00
210104	Урамшуулал	11,761,270.00	6,619,298.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	22,308,454.79	27,501,750.07
210201	Тэтгэврийн даатгал	14,691,413.49	18,834,472.62
210202	Тэтгэмжийн даатгал	2,433,228.93	2,210,478.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,415,193.98	1,768,382.11
210204	Ажилгүйдлийн даатгал	342,601.40	421,167.24
210205	Эрүүл мэндийн даатгал	3,426,016.99	4,267,249.94
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	23,384,002.62	29,057,069.52
210301	Гэрэл, цахилгаан	1,398,577.62	1,797,569.52
210302	Түлш, халаалт	20,445,425.00	24,729,500.00
210303	Цэвэр, бохир ус	1,540,000.00	2,530,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	21,764,619.00	29,103,343.00
210502	Хоол, хүнс	21,764,619.00	29,103,343.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	19,900,201.00	3,099,450.00
210604	Урсгал засвар	19,900,201.00	3,099,450.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	579,700.00	324,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	579,700.00	324,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	10,791,614.00	11,111,107.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,791,664.00	9,556,607.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,999,950.00	1,554,500.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>2,709,584.38</b>	<b>172,980.48</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,992,300.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,992,300.00	-
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	717,284.38	172,980.48
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	717,284.38	172,980.48
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>44,373,990.28</b>	<b>1,632,277.18</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>719,990.00</b>	-
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>719,990.00</b>	-
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	719,990.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	719,990.00	-

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(719,990.00)	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	43,654,000.28	1,632,277.18
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	43,654,000.21
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	43,654,000.28	45,286,277.39

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	83,079,720.00	520,683,037.07	603,762,757.07
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(603,398,902.07)	(603,398,902.07)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	83,079,720.00	(82,715,865.00)	363,855.00
Тайлант үеийн үр дүн	-	669,679,428.05	669,679,428.05
2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	83,079,720.00	586,963,563.06	670,043,283.06
2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	83,079,720.00	586,963,563.06	670,043,283.06
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	83,079,720.00	586,963,563.06	670,043,283.06
Тайлант үеийн үр дүн	-	(27,246,351.01)	(27,246,351.01)
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	83,079,720.00	559,717,212.05	642,796,932.05

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	365,683,500.00	320,267,492.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	365,683,500.00	320,267,492.34
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	365,683,500.00	320,267,492.34
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	259,127,700.00	221,462,222.75
210101	Үндсэн цалин	167,163,100.00	165,453,477.55
210102	Нэмэгдэл	84,916,800.00	47,689,447.20
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	1,700,000.00
210104	Урамшуулал	7,047,800.00	6,619,298.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,391,300.00	27,501,750.07
210201	Тэтгэврийн даатгал	22,026,200.00	18,834,472.62
210202	Тэтгэмжийн даатгал	2,591,100.00	2,210,478.16
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,072,800.00	1,768,382.11
210204	Ажилгүйдлийн даатгал	518,200.00	421,167.24
210205	Эрүүл мэндийн даатгал	5,183,000.00	4,267,249.94
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	29,229,500.00	29,057,069.52
210301	Гэрэл, цахилгаан	1,950,000.00	1,797,569.52
210302	Түлш, халаалт	24,729,500.00	24,729,500.00
210303	Цэвэр, бохир ус	2,550,000.00	2,530,000.00
2105	Нормативт зардал	31,595,300.00	29,103,343.00
210502	Хоол, хүнс	31,595,300.00	29,103,343.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,100,000.00	3,099,450.00
210604	Урсгал засвар	3,100,000.00	3,099,450.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	518,400.00	324,500.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	518,400.00	324,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>9,721,300.00</b>	<b>9,719,157.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,166,200.00	8,164,657.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,555,100.00	1,554,500.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>323,429,700.00</b>	<b>323,256,719.52</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>323,429,700.00</b>	<b>323,256,719.52</b>
122005	Орон нутгийн төсвөөс	323,429,700.00	323,256,719.52
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>42,254,000.21</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>-</b>	<b>45,278,227.39</b>

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 199.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 199.4 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлээ.

Дээрх албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл :

*/мянган төгрөгөөр/*

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлан дахь 199.4 мянган төгрөгийн өглөгийн тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	199.4			1	199.4						
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>199.4</b>			<b>1</b>	<b>199.4</b>						